

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

---

2020 оны . . . дугаар сарын . . .-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

**Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн  
бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хүсэлт гаргасан иргэний эзэмшсэн мэргэжлийн чиглэлийн дагуу техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцож, бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах ажлыг хамтран зохион байгуулж ажиллахыг Политехник коллеж, их дээд сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газар /Г.Батнэмэх/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/, Политехник коллеж, их дээд сургуулийн захирлуудад тус тус даалгасугай.

ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙД

С.ЧИНЗОРИГ

Ё.БААТАРБИЛЭГ

## **Техникийн боловсролын агуулга, багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмын төслийн танилцуулга**

Даяарчлагдаж буй дэлхий ертөнц, мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа иргэдэд хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадварыг бий болгох, насан туршдаа боловсролыг тасралтгүй эзэмших, мэдлэг, ур чадвараа үе шаттайгаар дээшлүүлэх хэрэгцээ бий болж байна.

Сургалтын тасралтгүй уян хатан тогтолцоог төрөөс хөхиүлэн дэмжих замаар техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчийн үнэлгээний дүнгийн голчийг харгалзан ижил төстэй мэргэжлийн чиглэлээр бакалаврын хөтөлбөрт багц цагаа дүйцүүлэн тооцуулж, зохих дамжаанаас элсүүлэн суралцуулах чиглэлээр Политехник коллеж, их дээд сургуулийн хамтын ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Иймээс Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болох бөгөөд багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах” заалтын дагуу ХНХ-ын сайд, БСШУС-ын сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулж батлуулахаар танилцуулж байна.

Энэхүү журмыг боловсруулах явцдаа өмнөх жилүүдэд дүйцүүлэн тооцож сургалт явуулж байгаа Политехник коллеж, их дээд сургуулийн мэргэжлийн чиглэл болон тоон үзүүлэлтийн судалгаа хийсэн. Судалгааны дүнд хөдөө орон нутгийн 6, Улаанбаатар хотын 6 политехник коллежийн техникийн боловсролын 62 мэргэжлийн чиглэлээс бакалаврын боловсрол олгох сургалтын 61 мэргэжлийн чиглэлд:

- 1.5 дахь жилээс 10 мэргэжлээр,
- 2 дахь жилээс 22 мэргэжлээр,
- 2.5 дахь жилээс 15 мэргэжлээр
- 3 дахь жилээс 11 мэргэжлээр
- 4 дэх жилээс 3 мэргэжлийн чиглэлээр тус тус шатлан суралцсан байна.

2017-2018 оны хичээлийн жилд 13 их, дээд сургуульд 783 суралцагч бакалаврын түвшинд дүйцүүлэн суралцсан байна. Судалгааны нэгтгэлээр 1999 оноос хойш 2851 суралцагч бакалаврын түвшинд багц цагийг сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд дүйцүүлэн суралцуулж төгсгөсөн байна.

Журмын төсөлд их, дээд сургууль, политехник коллежийн мэргэжлийн багш, сургалтын албаны дарга, арга зүйч нарын саналыг авч нэгтгэн тусгасан төдийгүй салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн холбогдох мэргэжилтэнүүд оролцсон 4 удаагийн томоохон хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Түүнчлэн журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны mlsp.gov.mn сайтад байршуулан <http://mlsp.gov.mn/nnews/261> линкээр холбож, и-мэйлээр оролцогч

талуудын саналыг авч нэгтгэн тусгасан. Энэхүү журам хэрэгжихтэй холбогдон нэмэлт зардал гарахгүй тул зардлын тооцоолол шаардлагагүй болно.

### **Шаталсан сургалтын давуу тал:**

1. Насан туршийн боловсрол, сургалтын олон улсын жишигт ойртоно.
2. Мэргэжлээрээ шатлан суралцаж, өндөр ур чадвартай мэргэжилтэн болно.
3. Сургалтын хөтөлбөр нь үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх, магадлан итгэмжлэгдэх боломжтой.
4. Шатлан суралцагчдад эдийн засгийн болон цаг хугацааны хэмнэлттэй, уян хатан нөхцөлөөр мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломж бүрдэнэ.
5. Мэргэжлийн ур чадвартай төгсөгчдөд их дээд сургууль нь ахисан түвшний онолын мэдлэг эзэмшүүлсэнээр инновацийг бүтээгч мэргэжилтэн бэлтгэгдэнэ.
6. Политехник коллеж, их, дээд сургуулийн багш нарын хамтын ажиллагааны үр дүнд мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
7. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, үр дүнд суурилсан боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын интеграци бий болж шатлан суралцах нөхцөл бүрдэнэ.
8. Их, дээд сургууль, политехник коллежийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.

ХНХЯ, БСШУС-ЫН ЯАМ  
ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ

### **Үндэслэл:**

7.4. Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болох бөгөөд багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/*

### **20 дугаар зүйл. Яам хоорондын хамтын ажиллагаа**

20.1. Яамд нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар хамтарч ажиллана. Хамтран ажиллах асуудлын хүрээ нь хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын үүрэг даалгавраар болон холбогдох яамдын удирдлагын түвшинд харилцан тохиролцсоноор тодорхойлогдоно.

20.2. Удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар яамд хоорондоо шууд харилцаж ажиллана.

20.3.Яамд нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

**Төсөл**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2020 оны . . . дугаар сарын . . . -ны  
өдрийн . . . . . дугаар тушаалын хавсралт

## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА, БАГЦ ЦАГИЙГ ДҮЙЦҮҮЛЭН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад болон гадаад улс орнуудад техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн иргэн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах үйл ажиллагааг (цаашид шаталсан сургалт гэх) зохицуулна.
- 1.2. Политехник коллеж, их дээд сургууль нь шаталсан сургалтыг зохион байгуулах ажлыг “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль” болон эдгээр хуулинд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 1.3. Шаталсан сургалтын элсэлтийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан их, дээд сургуульд оюутан элсүүлэх холбогдох журам, тогтоосон шалгуур, шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.
- 1.4. Шаталсан сургалтаар оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, хүртээмжтэй, тэгш байдлыг хангасан байна.
- 1.5. Их дээд сургууль, политехник коллеж нь шаталсан сургалт явуулах мэргэжлийн чиглэл, сургалтын хэлбэр, судлах хичээлийн багц цаг, суралцах жил, хугацаа, улирал, дүйцүүлэн тооцох үнэлгээний доод хязгаар, шилжүүлэн тооцох багц цагийн дээд хэмжээ болон холбогдох бусад асуудлыг хамтын ажиллагааны гэрээгээр харилцан тохиролцож болно.
- 1.6. Политехник коллежийн төгсөгчийг их, дээд сургуульд элсүүлэхэд суралцсан хугацаанд цуглуулсан багц цаг, голч дүнг ерөнхий шаардлага болгох бөгөөд хичээл бүрээр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг харгалзан тухайн хичээлийн багц цагийг дүйцүүлэн тооцох шийдвэрийг гаргана.
- 1.7. Их, дээд сургуулийн төгсөгч, политехник коллежид элсэн суралцах тохиолдолд *(БСШУЯ-ны Дээд боловсролын газартай тохирч, саналыг тусгах)*

### ХОЁР. БАГЦ ЦАГИЙГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ АРГАЧЛАЛ

- 2.1. Их, дээд сургууль, политехник коллеж нь шаталсан сургалт зохион байгуулах дараах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

- 2.1.1. Мэргэжлийн чиглэлийн дагуу бакалаврын болон техникийн боловсролын түвшний хөтөлбөр, төлөвлөгөөн дэх хичээлийн нэр, код зөрсөн тохиолдолд ижил болгох;
  - 2.1.2. Сургалтын төлөвлөгөөн дэх ижил төстэй хичээлүүдийн агуулга, багц цагийг үндэслэн энэхүү журмын хавсралтад тусгагдсан маягт (Хүснэгт-1)-ийн дагуу дүйцүүлэн тооцно<sup>1</sup>.
  - 2.1.3. Багц цагийг ялгаатай байдлаар тодорхойлон хэрэгжүүлж буй сургалтын байгууллагууд нь багц цагийг дүйцүүлэн тооцохдоо тухайн сургуулийн сургалтын багц цагийн тухай албан ёсны тайлбар авна. Энэ тохиолдолд тухайн багц цагт хамаарах суралцагчийн ачааллыг их, дээд сургуулийн багц цагийн харгалзах үзүүлэлтүүдэд шилжүүлэн тооцно.
- 2.2. Их, дээд сургууль нь элсэн суралцагчийн багц цагийг дараах байдлаар дүйцүүлэн тооцож, шаталсан сургалтын элсэлтийг зохион байгуулна. Үүнд:
- 2.2.1. Политехник коллежийн магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөс шатлан суралцсан оюутны судалсан хичээлийн багц цаг, авсан үнэлгээг шууд тооцож болно.
  - 2.2.2. Цаашид үргэлжлүүлэн судлах багц цагийн төлбөрийн хэмжээ нь тухайн их, дээд сургуулийн багц цагийн үнэлгээнд суурилна.
  - 2.2.3. Шаталсан сургалтыг хамтран зохион байгуулж буй их, дээд сургууль, политехник коллеж нь сургалтын төлөвлөгөөний ерөнхий, мэргэжлийн, мэргэшүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдээс дүйцүүлэн тооцох бүрэлдэхүүн хэсгийг сонгон урьдчилан тохиролцож, хамтын ажиллагааны гэрээнд тусгаж болно.
  - 2.2.4. Суралцагчийн судалсан багц цаг нь их, дээд сургуулийн харгалзах хичээлийн багц цагт хүрээгүй тохиолдолд, тухайн суралцагчийн үнэлгээний голч дүнг харгалзан хэдэн цаг нэмж судлах хэрэгцээг тооцоолно.
  - 2.2.5. Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон суралцахуйн үр дүн нь нийлж, их дээд сургуулийн харгалзах хичээлийн багц цаг, суралцахуйн үр дүнд хүрч байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн багц цагийг дүйцүүлэн тооцож болно.
  - 2.2.6. Энэхүү журмын 2.2.5 заасан хэд хэдэн хичээлийг нэгтгэн дүйцүүлж байгаа тохиолдолд үнэлгээг тухайн хичээлийн багц цаг, үнэлгээний жигнэсэн дундажаар тооцоолох ба бутархай үзүүлэлтийг ойролцоох бүхэл үзүүлэлтэд шилжүүлэн дараах байдлаар тооцоолно. Үүнд:

---

<sup>1</sup> Техникийн боловсрол сургалтын суралцахуйн үр дүн нь дээд боловсролын сургалтын байгууллагын харгалзах хичээлийн суралцахуйн үр дүнтэй 70-аас багагүй хувийн давхцалтай, багц цагийн зөрүү 0.5-аас ихгүй нөхцөлд, оюутан цаашид үргэлжлүүлэн суралцахад бэрхшээл учирхааргүй тохиолдолд дүйцүүлэх боломжийг нээнэ.

$$D = \frac{\sum_{i=1}^n Ki * Di}{\sum_{i=1}^n Ki}$$

Томьёоны тайлбар:

$n$ - Дүйцүүлэх хичээлийн тоо

$Ki$ - Тухайн ( $i$ ) дугаар дүйцүүлэх хичээлийн багц цаг

$Di$ - Тухайн ( $i$ ) дугаар дүйцүүлэх хичээлийн үнэлгээ

$D$  – Дүйцүүлэн тооцох үнэлгээ

2.2.7. Шатлан суралцагч нь гадаад хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын дээд онооны 60 хувь буюу түүнээс дээш үнэлгээтэй, хүчинтэй хугацаа бүхий албан ёсны гэрчилгээтэй тохиолдолд, нэмж судлах багц цагийг тооцно.

2.3. Шаталсан сургалтыг хамтран хэрэгжүүлж буй сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай бүрд албан ёсоор харилцан мэдэгдэнэ.

## **ГУРАВ. ШАТЛАН СУРАЛЦАГЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1. Бакалаврын хөтөлбөрт шатлан суралцах хүсэлт гаргагч нь техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн багц цагийг бүрэн судалсан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан тохиолдолд элсэн суралцана. Үүнд:

3.1.1. Голч дүн 3 ба түүнээс дээш бол элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгүйгээр;

3.1.2. Голч дүн нь 2-2.99 бол элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэйгээр;

3.1.3. Олон улсын болон үндэсний хэмжээний мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн бол бакалаврын хөтөлбөрт элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгүйгээр тус тус элсэнэ.

3.2. Дипломын сурлагын нийт оноо, голч дүнг харьцуулан тооцохдоо Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний их, дээд сургуулийн оюутны мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх журмын холбогдох заалтыг үндэслэл болгоно.

3.3. Шатлан суралцах хүсэлт гаргасан элсэгч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.3.1. Өргөдөл

3.3.2. Иргэний цахим үнэмлэх

3.3.3. Мэргэжлийн диплом

3.3.4. Элсэлтийн ерөнхий шалгалтад орсон батламж (3.1.1-д заасан голч дүнгийн шаардлага хангасан бол үл хамаарна.)

3.3.5. Амжилтын талаарх сургалтын байгууллага болон ажил олгогчийн тодорхойлолт.

- 3.4. Энэхүү журмын 3.1 дэх заалтын нөхцөлийг хангасан элсэгч нь мэргэжлээрээ ажилласан туршлагатай бол **өмнөх** мэдлэг, ур чадварын түвшинг үнэлж тооцох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг тухайн их, дээд сургууль дотоод журмын хүрээнд шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВ. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ**

- 4.1. Техникийн боловсролын хөтөлбөрөөс дүйцүүлэн тооцсон багц цаг, дээд боловсролын хөтөлбөрийн судалсан багц цагийн нийлбэр 120-иос доошгүй байна.
- 4.2. Бакалаврын хөтөлбөрт дүйцүүлж буй хичээл нь багц цагийн үнэлгээ, багц цагийн хэмжээ, шаардлагад нийцэж байгаа эсэхэд холбогдох мэргэжлийн тэнхим (мэргэжлийн багш) дүгнэлт гаргана.
- 4.3. Хичээл дүйцүүлэн тооцохдоо мэргэжлийн диплом дээрх тухайн хичээлийн судалсан багц цаг, үнэлгээг үндэслэл болгоно.
- 4.4. Хичээл дүйцүүлэлтийг элсэгчийн хүсэлтээр нэг удаа хийх бөгөөд энэ нь хугацааны хувьд уян хатан байж болно.
- 4.5. Дүйцүүлсэн багц цагийн тооцоог элсэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шатлан суралцуулах шийдвэрийг их, дээд сургуулийн эрх бүхий албан тушаалтан гаргана.
- 4.6. Их, дээд сургууль политехник коллежууд нь багц цаг дүйцүүлэн тооцохдоо дараах ажлыг хамтран зохион байгуулна. Үүнд:
- 4.6.1. Политехник коллеж нь их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагын хүрээнд техникийн боловсролын хөтөлбөрийн агуулгад заавал үзэх хичээлийг тусган судлах;
- 4.6.2. Шатлан суралцах хөтөлбөрийн хүрээнд их, дээд сургууль, политехник коллеж нь сургалтын хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж хичээлийн нэр, кодыг ижил болгох;
- 4.6.3. Хамтран ажиллаж буй их, дээд сургууль, политехник коллеж нь багш солилцооны хөтөлбөр, судалгаа шинжилгээ-инновацийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн туршлага хуримтлуулах, төгсөлтийн шалгалтыг хамтран зохион байгуулна.
- 4.7. Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох **хууль тогтоомжид нийцүүлэн** сургалтын байгууллага хоорондын хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулж болно.

## **ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

- 5.1. Шатлан суралцагчийн мэргэжлийн дипломыг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан голч дүнгийн шаардлага хангаагүй эсвэл элсэлтийн ерөнхий шалгалтын оноо хүрээгүй элсэгчийг элсүүлсэн их, дээд сургуулийн зохион байгуулсан шаталсан сургалтын элсэлтийг хүчингүйд тооцно.

ooOoo

ТӨСӨЛ



## ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ХҮСНЭГТ

... оны ... сарын ... өдөр

Оюутны овог:	Оюутны нэр:	Оюутны дугаар (ID):	Шатлан суралцаж буй дээд боловсролын сургалтын байгууллагын нэр:	Шатлан суралцаж буй хөтөлбөрийн нэр, индекс:		Төгссөн политехник коллежийн нэр:	Техникийн боловсрол сургалтын байгууллагад эзэмшсэн хөтөлбөрийн нэр, индекс:	
				Нэр	индекс		Нэр	индекс

№	Техникийн боловсрол сургалтаар судалсан дүйцүүлэн тооцох хичээлийн				Дээд боловсролын сургалтын байгууллагаар дүйцүүлэн тооцох хичээлийн			Дүйцүүлэн тооцсон байдал		Нэмж судлах шаардлагатай	Дүйцүүлэлт хийсэн багшийн нэр	Баталгаажуулсан албан тушаал	Баталгаажуулсан албан тушаалтны гарын үсэг
	Нэр	Код	Багц цаг	Үнэлгээ	Нэр	Код	Багц* цаг	Тооцсон багц цаг	Хувь	Багц цаг**			
1													
2													
3													
4													
5													
Нийт		Багц цаг			Нийт	Багц цаг		Нийт тооцсон багц цаг	Тооцсон багц цагийн хувь	Нийт			

№	Овог	Нэр	Гарын үсэг	Он.сар.өдөр
1	Дүйцүүлэлтийг хянаж, баталгаажуулсан албан тушаалтан			
2	Дүнг нэгтгэж оруулсан мэргэжилтэн			
3	Дүйцүүлэлтийг зөвшөөрсөн оюутан			
4	Шатлан суралцах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр шийдвэрийн дугаар, он. сар. өдөр			

\*- Дээд боловсролын сургалтын байгууллагад дүйцүүлэн тооцох хичээлийн багц цаг нь техникийн боловсрол сургалтаар судалсан хичээлийн багц цаг түүнээс дүйцүүлэн тооцсон багц цаг болон нэмж судлах шаардлагатай багц цагийн нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

\*\* - Нэмж судлах шаардлагатай багц цаг нь Дээд боловсролын сургалтын байгууллагаар дүйцүүлэн тооцох хичээлийн багц цагаас Техникийн боловсрол сургалтаар судалсан хичээлийн багц цаг түүнээс дүйцүүлэн тооцсон багц цагийн ялгавараар илэрхийлэгдэнэ.

Үнэлгээний голч дүн: Энэхүү журмын 3.1 дэх заалтад тусгагдсан техникийн боловсрол сургалтаар суралцсан нийт хугацааны голч дүн буюу мэргэжлийн диплом дээр тавигдсан үнэлгээний голч дүнгээр илэрхийлэгдэнэ.

ТӨСӨЛ